


Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар
тогтоолын хавсралт



“АХМАДАА АЧЛАЯ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР /2017-2020 он/

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийн 10 хүн тутмын 1 нь, улсын хувьд 20 хүн тутмын 1 нь, Ховд аймгийн хувьд 18 тутмын 1 нь 60-аас дээш насны ахмадууд байна. Гэхдээ хүн амын насны бүтцэд өөрчлөлт орж, дундаж наслалт уртасч байгаатай холбоотойгоор энэ тоо ойрын жилүүдэд 2 дахин өсөхөөр байна. Тухайлбал, сүүлийн 10 жилд Монгол улсын нийт хүн амын тоо 16,1 хувиар өссөн байхад өндөр настны тоо 21,9 хувиар буюу илүү хурдацтай өссөн байна. Энэ насжилтийн үзэгдэл нь Монголд төдийгүй дэлхий дахинд зайлшгүй тулгамдсан асуудал болоод байна.

Иймд ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт өсвөр хойч, залуу үеийнхэнд, хөдөлмөрийн хүмүүжил олгох, мэдлэг, туршлагыг залуу боловсон хүчинд өвлүүлэн үлдээх “Ахмадын зөвлөх үйлчилгээ”, ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлэх, “Насны хишиг” олгох зэрэг хөтөлбөр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилтыг тусгажээ.

Хоёр. Дэд хөтөлбөр боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага

Ховд аймаг нь 85,3 мянган хүн амтайгаас 7785 ахмад настан амьдарч байгаагаас хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа 444, эрсдэлт буюу эрсдэлд ойрхон нөхцөлд амьдарч буй 350, байнгын асаргаанд 938 ахмад настан, түүнчлэн ямар нэг байгууллага, аж ахуйн нэгжид харьяалалгүй 4271 ахмад настан байгаа судалгаа байна. Аймгийн хэмжээнд иргэдийн хөгжлийг хангахад чиглэгдсэн 10 гаруй дэд хөтөлбөр болон бусад бодлогын чанартай баримт бичгүүд хэрэгжиж байгаа ч олон үндэстэн, ястны төлгий, алслагдсан бүс нутагт оршдог тус аймгийн онцлогтой уялдсан ахмадуудад чиглэсэн хөтөлбөр батлагдаагүй байна.

Ахмад настан өөрийн чадавхидаа тохирсон хөдөлмөр эрхлэх, мэдлэг хандлагыг өөрчлөх асуудал чухлаар тавигдаж, нийгмийн амьдралын бүх хүрээнд цогц үйл ажиллагааг явуулах хэрэгцээ бий болсон байна.

Хувиараа хөдөлмөр эрхэлдэг ахмадууд өөрийн хийсэн бараа бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргах, тэтгэврээс өөр санхүүжилтгүй, өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа ахмадуудад чиглэсэн орлогыг нэмэгдүүлсэн оновчтой хөтөлбөр орон нутагтаа салбар дундын уялдаатай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дэд хөтөлбөрийг “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай”, “Нийгмийн халамжийн тухай” хуулиуд, “Монгол улсын хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги”, ахмад настнуудад тулгарч байгаа өнөөгийн хэрэгцээ шаардлага болон холбогдох бусад үндэсний хөтөлбөрүүд, “Ховд аймгийн хөгжлийн стратеги” /2015-2025 он/, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020 он/ түүнчлэн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хөдөө аж ахуй зэрэг бусад салбаруудын дэд хөтөлбөрүүдтэй уялдуулан боловсрууллаа.

Хоёр.Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго:

Ахмад настан нь нийгмийн эрх тэгш идэвхитэй гишүүн байж хөдөлмөр эрхлэх таатай боломжийг бий болгох, баталгаатай орлоготой байх, тэдний аж байдал нийгмийн хамгааллыг сайжруулах, эрүүл насжих, тэднийг нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэхэд төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог идэвхжүүлэх замаар хүний амьдралын чанарыг сайжруулах нөхцөл бүрдүүлэхэд оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

1.Ахмад настны нийгмийн оролцоог сайжруулж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх боломжийг дээшлүүлэх, зорилтот бүлэг ялангуяа харьяалалгүй иргэдийг нийгмийн халамжид хамруулах үр нөлөөтэй арга хэмжээ авна.

2. Хүн амын зорилтот бүлгийн хөгжил хамгааллыг сайжруулж, эрүүл насжихад бэлтгэх, эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгаа, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар ахмад настны эрүүл аж төрөх боломжийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ авна.

3.Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын ахмад настны талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлж, нийгэм хамт олны дунд амьдрах ээлтэй орчинг бүрдүүлэх, иргэд, олон нийтийн мэдлэг хандлагыг дээшлүүлнэ.

Гурав. Дэд хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ

Д / Д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага		Шаардагдах төсөв /төг/	
			Хариуцагч	Хамтрагч	Төг /сая/	Эх үүсвэр
1.Ахмад настны нийгмийн оролцоог сайжруулж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх боломжийг дээшлүүлэх, зорилтот бүлэг ялангуяа харьяалалгүй иргэдийг нийгмийн халамжид хамруулах үр нөлөөтэй арга хэмжээ авна.						
1	Аймгийн ахмадуудын нэгдсэн мэдээллийн сантай болох	2017-2020 он	ХХҮГ	Ахмадын хороо		Дотоод нөөц
2	Байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээх үйлсэд хувь нэмэрээ оруулж, жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоо тариалж буй ахмадуудыг төсөл хөтөлбөрт хамруулах	2017-2020 он	ХХҮГ	ХААГ Ахмадын хороо	20,0 сая	ХЭДСан
3	Ахмадуудад хүлэмж, бордоог хөнгөлөлттэй нөхцлөөр олгох, тэдний суулгацыг хотынхоо ногоон байгууламжид ашиглах замаар үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх	2017-2020 он	БОАЖГ	Ахмадын хороо	8,0 сая	Төсөл хөтөлбөр
4	Ахмад настнуудын боломж чадавхи дээр нь тулгуурлан төрөл бүрийн салбарт хөдөлмөр эрхлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжоор хангах	2018 оноос	ХХҮГ	Ахмадын хороо	10,0 сая	ХЭДС
5	Ахмад настныг гэрээр асрах, нөхөн сэргээх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж сайн дурын үйлчилгээг өргөжүүлэх	2018-2020 он	ХХҮГ	ТББ-ууд	20,0 сая	ОНХС Халамжийн сан ОНОТХҮ төсөл хөтөлбөр

6	Аймгийн ахмадын зөвлөгөөнийг 2 жилд нэг удаа зохион байгуулах	2018-2020 он	НБХ	ХХҮГ Сумдын ЗДТГ	10,0 сая	Орон нутгийн хөгжлийн сан
7	Нэвтийн амралтыг ахмадын рашаан сувилал болгон өргөжүүлж, иргэдэд хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчлэх боломжийг бүрдүүлэх	2017-2018	НБХ “Мянган угалзат” ОНӨҮГ	ХХҮГ, ЭМГ		Дотоод нөөц
2. Хүн амын зорилтот бүлгийн хөгжил хамгааллыг сайжруулж, эрүүл насжихад бэлтгэх, эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгаа, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар ахмад настны эрүүл аж төрөх боломжийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ авна.						
1	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагууд “Ахмадын сан” байгуулан тэтгэвэрт гарсан ахмад настнуудад нэмэгдэл тэтгэвэр тэтгэмж олгох, түлээ нүүрс, орон сууцны нөхцөл сайжруулах, хөдөлмөр эрхлэхэд нь туслах аян зохион байгуулах	2017-2020 он	НБХ ХХҮГ	Сумдын ЗДТГ	20,0 сая	“Ахмадын сан” Халамжийн сан, Бусад эх үүсвэрээс
2	Ахмад настанд орчин үеийн оношилгооны тоног төхөөрөмж эмч мэргэжилтэн бүхий эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийж эмчлэн сувилах багийг БОЭТ-д байгуулж ажиллах	2017-2020 он	ЭМГ	БОЭТ Ахмадын хороо	8,0 сая	ХЭДС Дотоод нөөц “Ахмадын зөвлөх үйлчилгээ”
3	Ажиллаж байсан байгууллага нь татан буугдсан болон өөр орон нутгаас шилжиж ирсэн харьяалалгүй ахмадуудыг судалж холбогдох үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	2017 он	Ахмадын хороо	Сумдын ЗДТГ УБХ		Дотоод нөөц
4	Тэтгэвэрт гарах хугацаа нь ойртож байгаа ахмадуудыг судлаж сэтгэл зүйн бэтгэл хангах, эрүүл аж төрөх, чадвар олгох сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах	2017-2018 он	ХХҮГ	Аймгийн ахмадын хороо	4,0 сая	Орон нутгийн хөгжлийн сан ХЭДСан
5	Ахмад настныг хаягийн бүртгэл иргэний харьяаллаас үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах арга хэмжээг авах	2017-2020 он	ЭМГ	БОЭТ Сумдын ЭМТөв		Дотоод нөөц
3. Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын ахмад настны талаарх ойлголт хандлагыг төлөвшүүлж, нийгэм хамт олны дунд амьдрах ээлтэй орчинг бүрдүүлэх, иргэд, олон нийтийн мэдлэг хандлагыг дээшлүүлнэ.						

1	Гэр бүл, үр хүүхэд нь ахмад настнаа хүндлэх зан үйлийг төлөвшүүлэхэд гэр бүлийн өдөр, ургийн баяр, насны ой зэргийг тэмдэглэхийг идэвхжүүлэх уриалга гаргах	2017-2020 он	ХХҮГ	БСУГ ГБХЗХГ		Дотоод нөөц
2	Ахмад настнууд өөр хоорондоо бүлэг, холбоо, клуб байгуулах замаар туршлага солилцох, бүтээгдэхүүн борлуулах үйл ажиллагааг дэмжих	2017-2020 он	ХХҮГ	Ахмадын холбоо	15,0 сая	ОНХС
3	Ахмад настнуудын дунд дуун цэнгүүн, урлаг, спортын тэмцээнийг сард нэг удаа зохион байгуулах	2017-2020 он	Ахмадын хороо	ХХҮГ БТСГ БСУГ Сумдын ЗДТГ		Дотоод нөөц
4	Жил бүр ахмадын баярыг өргөн хүрээтэй зохион байгуулахад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг татан оролцуулах аян зохион байгуулах	2017-2020 он	НБХ	ХХҮГ ААНБ-ууд		Халамжийн сан Бусад эх үүсвэр
5	Ахмадын ордныг түшиглэн “Хөгжлийн төв” бий болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	2018-2019 он	ХХҮГ	Ахмдын хороо	10,0	Төсөл, хөтөлбөр дэмжлэг
	НИЙТ ДҮН	Орон нутгийн хөгжлийн сангаас			40,0 сая	
Улсын төсөв болон Засаг даргын нөөцөөс			-			
Олон улсын төсөл, хөтөлбөр болон бусад сангийн дэмжлэгээр			86,0 сая			
Төсөв тодорхойгүй			-			

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа

4.1. Хөтөлбөрийн санхүүжилт

Дэд хөтөлбөрийн санхүүжилтыг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

1. Аймаг, орон нутгийн хөгжлийн сан
2. Олон улсын байгууллагын тусламж, дэмжлэг
3. Төрийн болон ТББ, аж ахуйн нэгж иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж хандивын хөрөнгө
4. Бусад эх үүсвэр

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Дэд хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2020 он хүртэл хэрэгжүүлнэ.

4.2.1. Нэгдүгээр үе: 2017-2018 он хүртэл орон нутгийн чадавхи бүрдүүлэх, сургалт, сурталчилгаа болон ахмадуудад чиглэсэн бодлого боловсруулах нөлөөллийн ажлуудыг бүх шатанд үе шаттайгаар зохион байгуулна.

4.2.2. Хоёрдугаар үе: 2019-2020 он хүртэл “Ахмадаа ачлая” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийж, эрчимжүүлэн дараагийн шатны зорилтоо тодорхойлно.

Тав. Хөтөлбөрийн тайлагналт:

5.1. Дэд хөтөлбөрийн биелэлтийн тайланг жилийн эцсээр гаргаж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүд

№	<u>Үзүүлэлт</u>	2016 оны түвшин	2020 онд хүрэх түвшин
1	Ахмадуудын талаар зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох оролцогчдын тоо	500	2500
2	Ахмадын бүлэг, хоршооны тоо	5	20
3	Эрүүл насжилтын хөдөлгөөнийг зан үйл болгон төлөвшүүлэх арга хэмжээнд оролцогчдын хувь	24%	50%
4	“Ахмадын сан”-тай болсон аж ахуйн нэгж, байгууллагын тоо	3	30
5	Харьяалалгүй ахмадуудын тоо	4500	3500
6	Урлаг, спортын тэмцээнд оролцогчдын тоо	250	1000

...оОо...